



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠨ ᠡᠳᠢᠶᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠳᠤᠯᠢᠨ  
ᠲᠠᠨᠢᠯᠴᠤᠭᠤᠯᠭ᠋᠎ᠠ










# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2021/10



БАГАНУУР ДҮҮРЭГ  
2021 он

## АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2021 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ҮНЭ ХАНШ	13
 АЖ ҮЙЛДВЭР	15
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2020 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	194 501	45 365	13 151	43 314	55 421	37 250
Үүнээс:						
Тэмээ	205	43	-	160	2	-
Адуу	15 294	4 205	801	3 737	3 539	3 012
Үхэр	18 067	4 687	1 693	4 128	4 289	3 270
Хонь	92 137	21 859	5 970	20 699	27 076	16 533
Ямаа	68 798	14 571	4 687	14 590	20 515	14 435

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-X	2018 I-X	2019 I-X	2020 I-X	2021 I-X
Суурин хүн ам	тоо	28 787	29 512	29 663	29342	
Төрөлт	тоо	506	547	519	497	474
Нас баралт	тоо	120	119	137	126	149
Шилжиж ирсэн	тоо	635	520	348	901	437
Цэвэр өсөлт	хувь	1.34	1.45	1.3	1.3	1.1'

'өмнөх оны суурин хүн амаас тооцов.

Зураг 1. Нутаг дэвсгэрийн хэмжээ






## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2021 оны 10 сарын эцэст 139 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 77 (35.6%) хүнээр буурсан байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 4 (2.9%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг 2. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 83 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 50 (60.2%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Ажил хайгч иргэд, шалтгаанаар



Мөн энэ хугацаанд 9 иргэн төсөвт байгууллагад ажилд орсон байна.

Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 15 (10.8%) нь 15-24 насны, 51 (36.7%) нь 25-34 насны залуучууд, 25 (18.0%) нь 35-44 насныхан, 36 (25.9%) нь 45-60 насны, 12 буюу (8.6%) нь 60-аас дээш насны иргэд байна.

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор, 10 сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2020 X	2021 X	2020 X	2021 X
Ажилгүйчүүд, бүгд	216	139	124	58
Үүнээс:				
Дээд боловсролтой	64	37	44	27
Тусгай дунд боловсролтой	14	14	8	10
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	30	13	14	3
Ерөнхий боловсролтой	102	74	57	40
Бага болон боловсролгүй	6	1	1	-

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 37 (26.6%) нь дээд боловсролтой, 14 (10.1%) нь тусгай дунд боловсролтой, 13 (9.4%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 74 (53.2%) нь ерөнхий боловсролтой, 1 (0.7%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 80 (57.6%) нь эмэгтэйчүүд байна.



#### НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 15.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.5 (10.6%) тэрбум төгрөгөөр, зарлага 23.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.0 (4.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 11.0 (69.7%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 986.5 (6.3%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 1.1 (6.7%) тэрбум төгрөг ҮОМШӨ сангаас, 2.5 (16.1%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 194.7 (1.2%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт	2020		2021		$\frac{2021.X\%}{2020.X}$	$\frac{2021.I - X\%}{2020.I - X}$
	X	I-X	X	I-X		
	сая төгрөг					
Сангийн орлого, бүгд	1 573.6	14 248.3	2 127.1	15 753.3	135.2	110.6
тэтгэврийн сан	1 049.2	9 503.3	1 430.1	10 981.9	136.3	115.6
тэтгэмжийн сан	110.4	1 000.0	150.5	986.5	136.3	98.7
ажилгүйдлийн сан	27.6	248.6	30.3	194.7	109.8	78.3
ҮОМШӨ <sup>1</sup> -ний сан	134.6	1 211.9	172.8	1 058.1	128.4	87.3
ЭМД <sup>2</sup> -ын сан	251.8	2 284.5	343.4	2 532.1	136.4	110.8
Сангийн зарлага, бүгд	2 304.7	22 425.0	2 371.8	23 428.6	102.9	104.5
тэтгэврийн сан	2 025.3	19 643.5	2 082.7	20 791.9	102.8	105.8
тэтгэмжийн сан	96.3	993.6	85.1	1 032.6	88.4	103.9
ҮОМШӨ-ний сан	149.1	1 456.2	156.9	1 344.5	105.2	92.3
ЭМД-ын сан	-	-	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	34.0	331.7	47.1	259.6	138.5	78.3

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4605 хүнд 20.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 2498 хүнд 1.0 тэрбум төгрөгийн тэтгэмж, 348 хүнд 1.3 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 153 хүнд 259.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 10 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 1.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.8 (52.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 1.6 (97.6%) тэрбум төгрөг улсын төсвөөс, 30.0 (1.9%) сая төгрөг орон нутгийн төсвөөс,

7.9 (0.5%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 443 хүнд 317.2 сая төгрөгийн тэтгэвэр, 394 хүнд 336.1 сая төгрөгийн асаргааны тэтгэмж, 1210 ахмад настанд 86.9 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 2974 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 306.7 сая төгрөг, 245 хүнд амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 278.7 сая төгрөг, 2 хүнд онцгой тохиодлын тэтгэмж 2.4 сая төгрөг, 54 хүнийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж 25.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 188 иргэдэд 47.4 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Зураг 7. Нийгмийн халамжийн сангийн орлогын бүтэц



## Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2020		2021		$\frac{2021.X\%}{2020.X}$	$\frac{2021.I - X\%}{2020.I - X}$
	X	I-X	X	I-X		
	Сая төгрөг					
Сангийн орлого	277.9	3 374.1	176.1	1 610.4	63.4	47.7
Улсын төсвөөс	277.9	3 292.6	175.5	1 572.5	63.2	47.8
Орон нутгийн төсвөөс	-	73.4	-	30.0	-	40.9
Бусад орлого	-	8.1	0.6	7.9	-	97.5
Сангийн зарлага	290.2	3 244.6	131.1	1 420.3	45.2	43.8
Тэтгэвэр	125.4	1 109.9	-	317.2	-	28.6
Тэтгэмж	31.7	323.8	32.3	336.1	101.9	103.8
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	28.2	236.6	25.7	278.7	91.1	117.8
"Алдарт эх" I одонт эхчүүд	-	120.4	-	-	-	-
"Алдарт эх" II одонт эхчүүд	0.3	134.3	-	-	-	-
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	-	8.5	-	-	-	-
Насны хишиг	-	235.5	-	-	-	-

Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	2.1	24.4	-	-	-	-
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	29.4	247.6	32.4	86.9	110.2	35.1
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	11.0	49.8	25.2	47.4	2.3*	95.2
“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	61.1	568.6	13.6	306.7	22.3	53.9
Цалинтай ээж	-	61.8	-	-	-!	-
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	-	58.4	-	-	-	-
ОНО-д түшиглэсэн халамж	0.9	30.0	1.8	25.8	2.0*	86.0
Ихэр хүүхдийн тэтгэмж	-	4.0	-	-	-	-
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	-	-	2.4	-	-
Бусад үйлчилгээ	0.1	31.0	0.1	19.1	100.0	61.6


\*дахин их



### ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 10 сарын байдлаар 486 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 35 (6.7%) буурсан байна. Энэ хугацаанд 123.6 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 54.6 (30.6%) мянган хүнээр буурч, хэвтэн эмчлүүлсэн 7.5 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 746 (11.0%) хүнээр өссөн байна.

Зураг 8. Амбулаторийн үзлэг 2021 оны X сар




Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл эхний 10 сард


Үзүүлэлт	2020 I-X	2021 I-X	$\frac{2021.I - X\%}{2020.I - X}$
Амаржсан эхийн тоо	521	485	93.1
Үүнээс бусад аймгийн харьяат	146	116	79.5
Амьд төрсөн хүүхэд	521	486	93.3
Үүнээс бусад аймгийн харьяат	145	117	80.7
Эхийн эндэгдэл	1	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	4	4	100.0



Зураг 9. Халдварт өвчин, сараар



Зураг 10. Ковид-19, сараар



2021 оны эхний 10 сарын байдлаар халдварт паразит өвчний 119 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 2.1%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 36 (23.2%) тохиолдлоор буурсан байна. Харин цочмог халдварт өвчний 5546 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 97.9%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 5465 (67.5 дахин) тохиолдлоор өссөн байна. Тайлант хугацаанд дүүрэгт Ковид-19 өвчний 5508 тохиолдол батлагдсан нь цочмог халдварт өвчний 99.3%-ийг эзэлж байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 1959.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1878.3 продицимиллээр өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2020 I-X	2021 I-X	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	155	119	-36
Заг хүйтэн	94	58	-36
Тэмбүү	30	32	2
Мөөгөнцөр /кандидоз/	4	1	-3
Трихомониаз	23	25	2
Кандилом	3	2	-1
Хламид	1	1	-
Цочмог халдварт өвчин	81	5 546	5 465
Цусан суулга	21	14	-7

Гепатит А	1	2	1
Салхин цэцэг	31	2	-29
Сальмонеллез	4	-	-4
Гар хөл амны өвчин	4	-	-4
Хачигт рикеттиоз	1	-	-1
Скарлатин	3	-	-3
Ковид-19	-	5 508	5 508
Сүрьеэ	13	20	7
Хоолны хордлого	3	-	-3
<b>Нийт халдварт өвчин</b>	<b>236</b>	<b>5 665</b>	<b>5 501</b>



### ГЭМТ ХЭРЭГ

2021 оны эхний 10 сард дүүргийн хэмжээнд 134 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 (8.1%) хэргээр нэмэгдсэн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 46.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.5 пунктээр буурсан үзүүлэлт юм.

#### Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-X	2021 I-X	Хэргийн өсөлт		Дунд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	124	134	10	8.1	100.0
Хүний амь нас хохироох	2	-	-2	-100.0	-
Хүний амь нас хохирсон	2	1	-1	-50.0	0.7
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	61	68	7	11.5	50.7
Бусдын эд хөрөнгө хулгайлах	21	14	-7	-33.3	10.4
Бэлгийн халдашгүй байдал	2	4	2	100.0	3.0
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	1	1	-	0.7
Дээрэмдэх	1	1	0	0.0	0.7
Залилан мэхлэх	13	19	6	46.2	14.2
Худал мэдээлэл тархаах	-	1	1	-	0.7
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	9	9	0	0.0	6.7
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	2	-	-2	-100.0	-
Мал хулгайлах	4	2	-2	-50.0	1.5
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах	1	-	-1	-100.0	-
Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хууль бусаар ашиглах	-	2	2	-	1.5
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	4	3	-1	-25.0	2.2
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	2	2	-	1.5
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	-	2	2	-	1.5
Хууль бусаар нийгмийн халамжийн үйлчилгээ авах	-	1	1	-	0.7
Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	-	1	1	-	0.7

Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	-	1	1	-	0.7
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	2	2	-	1.5
Бусад	2	-	-2	-100.0	-
Хэрэг илрүүлэлтийн хувь	54.1	46.6			

Зураг 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 68 (50.7%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 19 (14.2%) нь залилан мэхлэх хэрэг, 14 (10.4%) нь бусдын эд хөрөнгө хулгайлах хэргүүд байна.

Тайлант хугацаанд хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших хэрэг 9, бэлгийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 4, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэрэг 3, мөрийтэй тоглоом зохион байгуулах, мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хууль бусаар ашиглах, хууль сахиулагчийг эсэргүүцэх, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасан, мал хулгайлах хэрэг тус бүр 2, хүний амь нас хохирсон, гэр бүлийн хүчирхийлэл, дээрэмдэх, худал мэдээлэл тараах, хууль бусаар нийгмийн халамжийн үйлчилгээ авах, цахим мэдээлэлд хууль бусаар халдах, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэсэн хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Зураг 12. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Зураг 13. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний X сард




Хүснэгт 9. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-X		2021 I-X	
	Согтуугаар	Гудамж талбайд	Согтуугаар	Гудамж талбайд
Бүгд	52	28	66	20
Хүний амь нас хохироосон	1	1	-	-
Хүний амь нас хохирсон	-	-	-	1
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	50	12	55	8
Бэлгийн халдашгүй байдал	1	-	2	1
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	7	3	3
Залилах	-	2	-	-
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	1	1	-
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	3	-	5
Гэр бүлийн хүчирхийлэл	-	-	1	-
Бусдын эд хөрөнгө устгах гэмтээх	-	1	-	-
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	-	-	1
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	-	2	1
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	-	-	2	-
бусад	-	1	-	-
Дүнд эзлэх хувь	41.9	22.6	49.3	14.9

Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 66 болж өмнөх оны мөн үеэс 14 (26.9%) хэргээр өссөн бол, гудамж талбайд 20 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8 (28.6%) хэргээр буурсан байна. Мөн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 49.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.4 пунктээр нэмэгдсэн бол гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 14.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.7 пунктээр буурсан байна.

Зураг 14. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн I-X сар



### ҮНЭ ХАНШ


2021 оны 10 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 10. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2021 оны 10 сарын дундаж үнэ


Хүнсний бараа		Хэмжих нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1 775	1 750		1 800
	I зэрэг	кг	1 400	1 400		1 400
	II зэрэг	кг	1 050	1 050		1 050
Будаа	цагаан	кг	3 700	3 300		3 350
	шар	кг	3 380	3 150		3 000
Хонины мах	ястай	кг			9 500	
	цул	кг			11 500	
Үхрийн мах	ястай	кг			13 375	
	цул	кг			14 375	
Адууны мах, ястай		кг			9 850	
Ямааны мах		кг			8 500	
Элсэн чихэр		кг	2 800	2 600		2 540
Сүү /задгай/		л	2 000			
Тараг /задгай/		л	2 500			
Цэцгийн тос, Орос		кг	6 025	5 600		6 050
Байцаа		кг			2 500	
Манжин		кг			2 500	
Төмс	монгол	кг			2 000	
Лууван	монгол	кг			4 025	
Сонгино	хятад	кг			3 000	

	МОНГОЛ	КГ			3 200	
Сармис, булцуу		Ш			825	
Огурцы, хятад		КГ			16 250	
Помидор, хятад /үрлэн/		КГ			16 250	
Ургамлын тос/ siesta/		Ш	6 025	5 600		6 050
Өндөг		Ш	450	450		450
Талх	Есөн шанд	том 900 гр	Ш	2 000	2 000	2 000
		Дунд 700 гр	Ш	1 800	1 900	1 800
		жижиг 500 гр	Ш	1 500	1 700	1 500
	Атар талх	Ш	1 725	1 750		1 750

Зураг 15. “Алтан тариа” гурилын дундаж үнэ, жил бүрийн 10-р сард



Зураг 16. Нэг кг махны дундаж үнэ, жил бүрийн 10-р сард



Хүснэгт 11. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

	2018 X	2019 X	2020 X	2021 X
	төгрөг			
Адууны шир	10 000	5 000	6 500	5 000
Үхрийн шир /2.3 метрээс доош/	7 000	4 000	3 000	3 800
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	10 000	10 000	8 000	7 000
Хонины арьс	1 500	2 000	2 000	2 000

## Хүснэгт 12. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2017 X	2018 X	2019 X	2020 X	2021 X	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 480	1 750	1 810	1 450	2 040	590	40.7
АИ -92	1 630	1 900	1 860	1 470	2 070	600	40.8
Дизель түлш	1 720	2 230	2 390	2 180	2 550	370	16.7

2021 оны 10 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 600 (40.8%) төгрөгөөр өссөн байна.




### АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2021 оны эхний 10 сарын байдлаар 119.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10.8 (9.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

## Хүснэгт 13. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2020 I-X	2021 I-X	$\frac{2021}{2020}$ %	2020 I-X	2021 I-X	$\frac{2021}{2020}$ %
Нүүрс олборлолт	м.тн	3 098.6	3 410.3	110.1	103 803.1	114 245.7	110.1
Дулаан дамжуулалт	м.гкал	119.6	117.3	98.1	3 916.5	4 042.1	103.2
Талх үйлдвэрлэлт	тн	173.3	195.3	112.7	243.7	290.3	119.1
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	38.1	46.3	121.5	310.6	431.8	139.0
Зайлуулсан хог хаягдал	м.м3	40.8	46.3	113.5	414.0	466.2	112.6
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					108 687.9	119 476.1	109.9


Зураг 17. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар




Оны эхний 10 сарын байдлаар нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 311.7 (10.1%) мянган тонн, үнийн дүнгээр 10.4 (10.1%) тэрбум төгрөгөөр өссөн бол, дулаан үйлдвэрлэлт 2.3 (1.9%) мянган гкал-аар буурч, үнийн дүнгээр 125.6 (3.2%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 22.0 (12.7%) тонноор, үнийн дүнгээр 46.6 (19.1%) сая төгрөгөөр, нарийн боовны үйлдвэрлэлт 8.2 (21.5%) тонноор буюу 121.2 (39.0%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд 46.3 мянган м3 хог зайлуулсан нь өнгөрсөн оноос 5.5 (13.5%) мянган м3-аар нэмэгджээ.

Зураг 18. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, сая төгрөг



Зураг 19. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн X сард








## НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 1945.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 272.6 (16.3%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 1001.7 (51.5%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 14. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

Үзүүлэлт	2020 I-X	2021 I-X	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	1 673.0	1 945.6	272.6
Орон сууц	313.5	404.7	91.2
Ус борлуулалт, бүгд	685.8	839.4	153.6
Хүн амд	325.3	446.9	121.6
Аж ахуйн нэгжид	360.5	392.5	32
Сувагжуулалт	567.5	624.1	56.6
Бусад	106.2	77.4	-28.8

Зураг 20. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 15. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	484 646.7	421 370.4	86.9
Тавлаг өргөө	82 505.0	67 204.8	81.5
Маргад өргөө	87 938.5	67 376.0	76.6
Сод хөгжил	107 249.0	104 800.9	97.7
Шинэ элч	85 956.7	75 650.3	88.0
Уурхайчин	69 609.5	64 457.7	92.6
Содон суварга	51 388.0	41 880.7	81.5

**WWW.1212.MN** СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах  
ТОГЛООМ 

Валютын ханш 




аппликейшнаас  
**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ**

**Data lab** | тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**

 [www.facebook.com/StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)

 [www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



[information@nso.mn](mailto:information@nso.mn)